



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар A/41

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын үндсэн эд хөрөнгө, материалын 2024 оны жилийн эцсийн тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
- Гишүүд: Сургалт, судалгаа, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
Архив, бичиг хэргийн эрхлэгч

Нарийн бичгийн дарга: Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер

2.Тооллогын комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ